

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ШИНЭЧЛЭЛ POLICE REFORM



Ж.Ганбаатар. Цагдаагийн ерөнхий газрын дэд бөгөөд Дэмжлэг үзүүлэх газрын дарга, дэд комиссар
Ganbaatar.J. Deputy Commissioner and head of Supporting Department, National Police Agency, vice commissary

Abstract: The police in Mongolia shall be developed in accordance with which the modern trend and development of the law enforcement process, standards of its activities, skill based training and smart structure which is close to the public and citizens.

Орчин үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чиг хандлагыг цагдаа судлаач Роберт Пийл тодорхойлохдоо чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц гэсэн үндсэн асуудлыг хөндөж тависан байдаг.

Мөн судлаач Дэвид Бейлий орчин үеийн цагдаа гэж нийтийн эрх ашигт нийцсэн, тусгай чиг үүрэг бүхий, мэргэжлийн байгууллага гэж томъёолсон.

Харин бодлого арга зүйн хувьд нийгмийн өмнө тулгамдсан тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, олон нийтийн туслалцаа дэмжлэгийг авах, хуулиар хүлээлгэсэн эрх, үүрэг бүрийг нэгбүрчлэн биелүүлэх, мэдээлэлд суурилсан үйл ажиллагаа явуулах зэрэг цагдаагийн үйл ажиллагааны стратеги хэлбэрүүд төлөвшин хөгжиж өнөөг хүрсэн.¹²⁴

Эдгээрийг нэгтгэж дүгнэвэл “reactive” буюу гомдол мэдээлэлд тулгуурласан үйл ажиллагаа, “Proactive” буюу өөрсдийн идэвхи санаачилгаар чиг үүргээ биелүүлэх үйл ажиллагаа гэсэн 2 хэсэгт хувааж болно.¹²⁵

Орчин үеийн цагдаа болж хөгжих зорилго тависан бол өөрсдийн идэвхи санаачилгаар нийгмийн сөрөг үзэгдэл дунд нэвтэрч тэдгээрийн мөн чанарыг цаг алдалгүй танин мэдэх “Proactive” үйл ажиллагаа бидэнд хэрэгтэй.

Цагдаагийн албаны тухай хууль батлагдан гарснаар нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн үүргийг тодорхой болгож, цагдаагийн төв байгууллагаас

мэргэжлийн удирдлага, стандарт тогтоох хэлбэрээр нутаг дэвсгэр хариуцсан цагдааг хөгжүүлэх боломж бүрдсэн.

Хэдийгээр Цагдаагийн албаны хууль шинээр батлагдсан боловч цагдаад хамааралтай хууль тогтоомжийн болон хууль сахиулах салбарын системийн шинэчлэл эхлэлийн шатандаа байна гэхэд болно.

Дэлхий нийтийн жишгээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь тухайн улс орны эрүүгийн процессийн төрөлжсөн¹²⁶ хууль байхаас гадна шинээр байгуулагдсан хууль сахиулах албадын тогтолцоо харилцан холбоо байдаг.

Иймд Монгол Улсын хууль сахиулах албаны шинэтгэлийг цагдаагийн шинэчлэлээр эхлүүлж, цагдаа, тахар, гадаадын иргэн, харъяатын алба гэх мэтчилэн хууль сахиулах албад чиг үүргээсээ үл хамаарч нэгэн цул тогтолцоо болж хөгжих бодлого хэрэгжиж байгаа юм.

Өмнө нь иргэний бүртгэл, шүүх шинжилгээ, тахар, гадаадын иргэн, харъяатын алба гээд бүгд л цагдаагийн байгууллагын бүтцийн нэгж байсан. Энэ үедээ нэг удирдлага, хууль эрх зүйн орчинд үйл ажиллагаа явуулж ирсэн. Харин одоо тус бүр бие даасан албад болцгоосон.

Хууль сахиулах байгууллагууд салж нийлэх нь зарчмын хувьд гол анхаарал татсан асуудал биш. Яагаад гэвэл аливаа үүссэн нөхцөл байдлаас шалтгаалж тэд нэг л зорилготой, өдөр тутам нэг байгууллага шиг хамтарч ажиллах шаардлага бий

¹²⁴ Samuel Walker, The Police in America, Fifth Edition, 2005, p10

¹²⁵ Ж.Ганбаатар, Цагдаагийн байгууллагын эрх зүйн бодлого, цаашдын чиг хандлага, Цагдаагийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд тавьсан илтгэл, 2010 он

¹²⁶ Мөн тэнд

болдог.

Жишээ нь гадаадын иргэнтэй холбоотой гэмт хэрэгт цагдаа, гадаадын иргэн харьяатын алба, хэргийн оролцогчийг хил нэвтрүүлэхийг хориглох ажиллагаанд цагдаа, хил хамгаалах байгууллага, аж ахуйн нэгжийн эсрэг гэмт хэрэгт цагдаа, иргэний бүртгэл, гэмт хэргийн газар, нотлох баримтын шинжилгээнд цагдаа, шүүхийн шинжилгээ зэргээр хоорондоо байнга холбогдож ажилладаг.

Харин бүгд бие даасан чиг үүрэгтэй байгууллагууд болж өөрчлөгдсөнөөр харилцаа холбоогоо санамж бичгээр илэрхийлдэг, нэгдсэн арга хэмжээ хамтран зохион байгуулдаг зэрэг явцуу байдлаар харилцдаг болсон. Өөрөөр хэлбэл эдгээр байгууллагууд нэгдсэн бодлогоор хангалттай түвшинд харилцаж ажилладаггүй.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар 2010 онд зохион байгуулсан “Шударга ёс” Үндэсний зөвлөгөөнд уг асуудалд шүүмжлэлтэй хандаж “хуулийн байгууллагууд газар доорх дулааны шугамаараа холбогддог боловч ажил хэрэг дээр хоёр тийшээ харж суудаг” гэсэн бодитой дүгнэлт хийхэд хүрсэн.

Улмаар 2013 онд ухаалаг төр /smart government/ цогцлоон бүтээх уриан дор хуулийн засаглал, ил тод нээлттэй, иргэдийн оролцоотой, аюулгүй нийгмийг бий болгон, илүү зардлыг хэмнэх, ажил үүргийн давхардлыг арилгах, төрийн албанд хууль бус томилгоо хийхийг хязгаарлах, ухаалаг албатаар хүний нөөцийг бүрдүүлэх зарчмын асуудлууд тавигдаж эхэллээ.¹²⁷

“Цагдаагийн байгууллагын тухайд дэд бүтцийн шинэчлэл хийж иргэнд биш, даргад үйлчилдэг, хүчний маягийн цэрэгжсэн, мөрдөс, цолондоо юунаас ч илүү хайртай байх тогтолцоог өөрчлөх, үндсэн чиг үүргийн болон дэмжлэг үзүүлэх боловсон хүчний харицааг зөв зохистой төлөвлөх ажил хийгдэж эхэлсэн.”¹²⁸

Жишээ нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрыг байгуулж 1000 гаруй дотоодын цэргийн алба хаагчийг цагдаагийн мэргэшсэн албан тушаалд томилохоор сургалтанд хамруулж, Засгийн газраас тогтоосон жишиг нормативын дагуу хүн амын нягтаршлыг харгалзан дүүргийн цагдаагийн хэлтсүүдийг нэмж байгуулж байна.

Дээрх арга хэмжээг 2009 онд Цагдаагийн ерөнхий газраас хийсэн судалгаанд¹²⁹ үндэслэн зохион

байгуулсан гэхэд болно. Учир нь энэ судалгаагаар хүн амын өсөлт, хотжилт, шилжилт хөдөлгөөнийг тооцоолж цагдаагийн жишиг норматив боловсруулан ажлын ачаалал, орон тооны зохион байгуулалт хийх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан.

Түүнчлэн цагдаагийн байгууллагад гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах шууд үүрэгтэй болон захиргааны ажилтны зохистой харьцаа бий болоогүй буюу тухайн үеийн судалгаагаар нийт гэмт хэргийг нийт алба хаагчид хуваахад 350, харин шууд үүрэг хүлээсэн алба хаагчид хуваахад энэ тоо 2 дахин өсч 784 болж байгааг анхааруулсан байдаг.

Эдгээрээс гадна гадаадын шинжээч Ирвин Бейкин, Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа болон чадавхийн үнэлгээ хийх явцдаа цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг стандартад оруулж, Хууль зүйн яамнаас хяналт тавих журмыг боловсруулах, цагдаагийн менежементийг сайжруулж, удирдах ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, төлөвлөгөө, тайлангийн биелэлтэд үнэлгээ шинжилгээ хийсний үндсэн дээр нэн даруй стратегийн баримт бичигтэй болох шаардлагатай байгааг дүгнэлтэндээ тусгаж байсан.¹³⁰

Түүний дүгнэлтэд үндэслэн 2010 онд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, 2014 онд Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг тус тус боловсруулсан. Цаашид цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд олон удаа өөрчлөлт оруулан сайжруулж, хууль зүйн яамны хяналтад оруулан хууль сахиулах ажиллагааны жишиг норматив болгоно.

Үүгээр цагдаагийн байгууллага хууль сахиулах салбартаа тэргүүлэн үлгэрлэх боломжийг эрэлхийлж байгаа юм.

Ирвин Бейкин дүгнэлтэндээ цагдаагийн хүний нөөцийг тооцоо судалгаанд үндэслэн сонгон шалгаруулж авах, үр дүнтэй давтан сургах, ажил дүгнэх үзүүлэлтийг шинэчлэх, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад шийдвэр гаргах эрхийг өгөх, цагдаагийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож, өдөр тутмын ажлын бүртгэл мэдээлэлд нэвтэрч шуурхай үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх хэрэгтэй гэсэн байдаг.

Түүний илтгэлд: дүүргийн цагдаагийн эрүүгийн тасгийн дарга нь гэмт хэрэгтнийг эрэн сурвалжлахад нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагуудын мэдээллийн сүлжээ сайн байх ёстой гэсэн мөртлөө хангалттай программ хангамж, мэдээллийн технологийн сүлжээ тавигдаагүй байна гэж дурьдсан.

Эдгээр дүгнэлтийг ажил хэрэгч хүлээж авбал юуг шинэчлэх бодит шаардлага байгааг мэдэж болох төдийгүй хэрэгжүүлэх арга замыг ч төлөвлөх боломжтой юм.

Жишээ нь сэжигтний хурууны хээ, зургийн сан,

¹³⁰ Ирвин Бейкин, Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа болон чадавхийн үнэлгээ, 2007 он, 4-14, 26, 27 дахь тал

¹²⁷ “Том төрөөс ухаалаг төр лүү” Үндэсний зөвлөлдөх уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн хийсэн танилцуулга, 31, 46 дахь тал 2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр, Төрийн ордон

¹²⁸ Х.Тэмүүжин, Цагдаагийн байгууллагад хийж буй шинэтгэлийн талаар сэтгүүлчидтэй хийсэн зангиагүй уулзалт, 2013

¹²⁹ Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах шууд үүрэгтэй алба хаагчийн ажлын ачааллыг гаргах судалгаа, 2009 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр, Цагдаагийн ерөнхий газар

жолоочийн ухаалаг үнэмлэх, тээврийн хэрэгслийн бүртгэл, хулгайд алдагдсан эд зүйлийн бүртгэл зэрэг нь саатуулагдсан этгээдийг шалгах явцад заавал нэвтэрч тулгалт хийх ёстой программууд юм.

Цагдаагийн байгууллагад хандаж ирсэн иргэдийн мэдээллийг цахим хэлбэрээр бүртгэх, гомдол мэдээлэл хүлээж авах, бүртгэх журам стандарттай болох, мөрдөн шалгах ажиллагааны процессийг боловсронгуй болгох, цагдаагийн байгууллагыг одоо байгаагаас нь илүү нээлттэй, ил тод болгох, гэрч хохирогчийг хамгаалах орчин бүрдүүлэх зэрэг технологийн шинэчлэлүүд ч мөн ялгаагүй шаардлагатай болох нь мэдрэгдэж байна.

Ихэнх улс орнуудад цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны дэг горимыг тогтоохдоо цагдаагийн алба хаагчийн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулахад биеийн хүч, галт зэвсэг тусгай хэрэгсэл ашиглах, тэрчлэн гэмт хэрэгт сэрдэгдсэн хүнийг баривчлах, саатуулах, хорих, үзлэг нэгжлэг хийх эрхийг хууль сахиулах процессийн хуульд зааж өгсөн байдаг.

Жишээ нь хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль, гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулиар цагдаа төдийгүй хууль сахиулах байгууллагын тодорхой үйл ажиллагааг нэгдсэн стандарттай, нарийвчилсан зохицуулалттай оруулах боломж бүрдэнэ.

Нөгөө талаар одоо байгаа хууль эрх зүйн орчинд хийх боломжтой зүйлийг заавал шинэ хуулийн орчин шаардаж хүлээлт үүсгээд байх учиргүй. Жишээ нь, гэмт хэрэг, зөрчлийн тухай нэр, хаяггүй гомдол, мэдээллийг цагдаагийн байгууллагад гаргах асуудлаар иргэдээс санал асуулга авч байна.

Гэмт хэрэг, зөрчлийн тухай нэр, хаяггүй гомдол, мэдээллийг цагдаагийн байгууллага авч шалгах, улмаар хэргийн бодит үнэнийг тогтоох сэтгүүл болгон ашиглахад хуулиар хориглосон ямар ч зохицуулалт байхгүй. Энэ нь гагцхүү бидний сэтгэл, сэтгэлгээний асуудал юм.

Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг, зөрчлийн тухай нэр, хаяггүй гомдол, мэдээллийг цагдаагийн байгууллага авч шалгах нь гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа биш, харин хууль сахиулах үйл ажиллагаа юм.

Цагдаагийн байгууллагын шинэчлэлийн асуудал нь түүний үйл ажиллагааны процесс ямар байхаас гадна үйлчилгээний чанар хүртээмж, боловсон хүчний зан харьцаа зэрэг олон нийтийн санаа бодол, үнэлэмжид тулгуурласан байх ёстой.

Тухайлбал, Максима төвөөс¹³¹ 2007 онд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар судалгаа явуулж гаргасан дүгнэлтэндээ цагдаагийн байгууллагад хийж байгаа шинэчлэл нь олон

нийтийн хүсэн хүлээж байгаа түвшинд хүрэхгүй байна. Үүнд цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл хангалтгүй, хариуцлагагүй ажилчдын бүтээлч сэтгэлгээ сул, давтан сургалт үр дүнгүй зэрэг сөрөг хандлага нөлөөлж байгааг сануулсан.

Энэ байгууллага 2013 онд Цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар ахин үнэлгээ судалгаа явуулахад¹³² цагдаагийн байгууллага дээр хэрэгжүүлж байгаа өөрчлөлтүүд нь "цагдаагийн үйлчилгээг иргэдэд ойртуулахад" 72,6%, "алба хаагчдын ёс зүйн төлөвшилд" 55%, "алба хаагчдын ажилдаа хандах хандлагад" 57,7%, "цагдаагийн үйлчилгээ иргэдэд ойртоход" 63%, "цагдаагийн үйл ажиллагаа иргэдэд ил тод болоход" 58%-иар сайнаар нөлөөлж байна хэмээн цагдаагийн алба хаагчид үнэлсэн байдаг.

Түүнчлэн цагдаагийн байгууллагын гэмт хэргийг илрүүлэх ажилд иргэдийн 40% нь эерэг үнэлгээ өгсөн бол цагдаагийн алба хаагчдын 81,4% нь эерэг үнэлгээ өгсөн байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн 30% нь эерэг үнэлгээ өгсөн бол цагдаагийн алба хаагчдын 71,3% нь эерэг үнэлгээ өгсөн байна. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд өгч буй үнэлгээгээр иргэд болон цагдаагийн алба хаагчдын үнэлгээ 2 дахин илүү зөрүүтэй байгаа нь цагдаагийн үйл ажиллагаа хангалтгүй байгааг, цагдаагийн алба хаагчдын өөрийн үнэлгээ бодит биш байгааг, иргэдийн эрх ашгийн үүднээс цагдаагийн ажилд үнэлгээ өгөх бодит шалгуур үзүүлэлт нэвтрээгүй байгааг илтгэж байна гэжээ.

Үүнээс үзвэл цагдаагийн байгууллагад шинэчлэл хийх нь зөв гэж байгаа боловч юунаас эхэлж шинэчлэх, алба хаагчид ямар үүрэгтэй оролцох зэрэг асуудлыг хөндөж тавихаас өөр аргагүй байна. Учир нь цагдаагийн шинэчлэл, үйл ажиллагааны талаар / түүний мөн чанар, цар хүрээ/ иргэд болон цагдаа хоёр хоорондоо эрс тэс бодол санаатай байна. Үүнд байгууллагаас ямар нэгэн мониторинг одоогоор хийгээгүй байна.

Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд цагдаагийн ажилтныг хуулиар хүлээсэн үүрэг, даргаас тавьсан шаардлагын зэрэгцээ хариуцсан нутаг дэвсгэрт оршин суугаа иргэд цагдаагаас юу хүсэж найдаж байгааг мэдэрч ажиллах¹³³ дадал зуршилд сургах хэрэгцээ бий болж байгаа юм.

Хэрэв ийм дадал чадвар хандлага бий болгох сургалт, ажлын арга барилыг нэвтрүүлчихвэл ажлын доголдол үүсэхгүй. Үүний үндсэн санаа ч сургалтын шинэчлэл хэрэгтэй байгааг сануулж байна.

Ингэж чадвал шинэчлэгдэж байгаа цагдаагийн байгууллага, алба хаагчид өөрсдийн үйл ажиллагаандаа олон улсын стандартыг баримталж, зан суртахуун, ёс заншил, хууль эрх зүйн холимог

¹³¹ Максима төвөөс 2007 онд хийсэн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх судалгааны танилцуулга, 2008 оны 03 дугаар сарын 04-ний өдөр, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн тасаг

¹³² Максима төвөөс 2013 онд Цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх үнэлгээ судалгаа, 6 дахь тал

¹³³ Criminal Justice, Robert M.Bohm, 2003, p 190

тогтолцоонд ажиллаж сурах чадвартай, өөрөөр хэлбэл бид өөрсдийгөө Multicultural society буюу олон улсжсан нийгэмд уян хатан ажиллах боломжтой болгон хөгжүүлнэ.¹³⁴

Үүний тулд цагдаагийн байгууллагыг иргэний хяналтад оруулах /иргэний зөвлөл/ эрсдлийн үнэлгээ шинжилгээ хийх, бодит нөөц бололцоогоо танин мэдэх, төсвөө хэмнэхийн зэрэгцээ алба хаагчийн аюулгүй байдлыг хангах бодлогыг орхигдуулахгүй байх¹³⁵ хэрэгтэй болно.

Жишээ нь цагдаагийн тусгай хэрэгсэл, галт зэвсгийг сайтар эзэмшсэн, үүссэн нөхцөлд тохируулан хэрэглэж чадах алба хаагч хэд байна, тэд үүрэг гүйцэтгэхдээ хутганаас хамгаалах хантааз өмсөж байна уу, төсөв хангалттай шийдвэрлэж өгөөгүйн улмаас 2 алба хаагчийн дунд 1 хантааз тавихад хүрч байна зэрэг олон асуулт гарч ирнэ.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий иргэдийн төлөөлөөс бүрдсэн орон тооны бус Иргэний зөвлөл аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд ажиллана.

Хууль зүйн сайдын тушаалаар батлах иргэний зөвлөлийн дүрмийн төслийг Нээлттэй нийгэм форумтай хамтран олон нийтэд хэлэлцүүлж, нутаг дэвсгэрийн төр захиргааны байгууллагуудын саналыг тусган нэгтгэсэн.

Цаашдаа иргэний бодит хяналтын дор цагдаагийн байгууллага үйл ажиллагаагаа явуулна.

Үүнээс гадна цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, ажлын онцлог бэрхшээл, ур чадварын талаар олон нийтэд төдийлөн дэлгэрэнгүй төсөөлөл байдаггүй. Үүний гол шалтгаан нь байгууллагын "PR" буюу олон нийт рүү чиглэсэн сурталчилгаа маркетинг хөгжөөгүй байгаагаас юм.

Жишээ нь цагдаагийн байгууллагын олон нийттэй харилцах бодлогын үндсэн сэдэв нь гэмт хэргийн тухай мэдээ сэрэмжлүүлэг. Гэтэл мэдээллийн хэрэгслүүд үүнээс дэлгэрэнгүй мэдээллийг албан ёсны мэдээлэл гарахаас өмнө олон нийтэд хүргэж байна.

Олон нийттэй харилцах, хэвлэл мэдээллээр тарааж байгаа сөрөг мэдээллийг судалж удирдах, хяналт тавих, нөлөөллийг бууруулах, эргээд тодорхой үйл ажиллагааны заавар болгож ашиглах зэрэг шинэчлэхээр зүйл цөөнгүй.

Үүнээс гадна Цагдаагийн ерөнхий газрын ажлын төлөвлөгөө, тайлан, шинээр нэвтрүүлсэн ажил үйлчилгээ гээд олон нийтэд мэдээлж санал шүүмжлэлийг авах олон сэдэв байдаг.

Ингэж тайлагнаснаар бидний ажилд хор уршиг

¹³⁴ The South Australia Police, Future Directions strategy, 2006-2010, John lockyer, The Police: NZ 2010, Detective, Christian Ellis, The National Intelligence Model, Presentation; Performance Management Framework, 2012, www.crimestopper-uk.org/give-information/give-information-online/

¹³⁵ Charles McClelland, We reduced crime rates with a reduced budget, The Police Chief, October 2012, p 18

учруулахгүйгээр үл барам цагдаа олон нийтийн хамтын ажиллагааг дээшлүүлэхэд, мөн тэдний нэр хүндийг дээшлүүлэхэд чухал хүчин зүйл болдог. Үүний тулд цагдаагийн үнэлгээ шинжилгээ, дотоод асуудал эрхэлсэн болон олон нийттэй харилцах нэгжүүд өдөр тутам хамтарч үйл ажиллагаагаа боловсронгуй болгож байх ёстой.

Цагдаагийн алба хаагчдын дунд сэтгэлгээний өөрчлөлт бий болгох нь энэ илтгэлд дурьдсан шинэчлэлийн асуудал бүрээс хамгийн чухал, мөн хамгийн их цаг хугацаа, хөрөнгө мөнгө шаардсан асуудал юм.

Өөрөөр хэлбэл хэвшиж тогтсон хандлага, ажлын арга барилыг өөрчлөх гэдэг нь хууль гаргаад шийдвэрлэгдэхгүй, харин цагдаагийн удирдлагаас ихээхэн ухаан, системтэй бодлого үйл ажиллагаа шаардсан менежемент байдаг.

Жишээ нь боловсон хүчний мэргэжлийн ур чадвар, гадаад хэлний мэдлэгийн түвшинг тогтоох, хооронд нь шударгаар өрсөлдүүлж албан тушаал, цол хэргэм хүртэх боломжийг нээж өгнө. Ийм тогтолцооны шинэчлэлийг хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд тусгасан.

Мөн ажилтан өөрийнхөө хийж байгаа ажлыг юу гэж ойлгодог, ажлын байр/албан тушаал/-ын тодорхойлотыг боловсруулах шалгуур үзүүлэлт зэргийг нягтлан үзэх хэрэгтэй болох нь ойлгомжтой.

Жишээ нь Мэдээллийн шинжилгээ, криминологийн хэлтэст ажиллаж байгаа алба хаагчид дээрх асуултыг тавихад мэдээллийн шинжээч /intelligence analyst/, судлаач /researcher/ гэсэн ажлын байрны нэрийг тэд санал болгоно. Учир нь эдгээр ажлын байрны нэрийг цагдаагийн байгууллага дахь ажлын байрны нэрийг тодорхойлоход олон улсын түвшинд түгээмэл хэрэглэдэг гм. Өөрөөр хэлбэл шинэчлэлийг алба хаагчдаар өөрсдөөр нь үйлдүүлэх хэрэгтэй.

Цагдаагийн байгууллагын чадавхийн үнэлгээ судалгааг тогтмол хийж өнөөгийн эрүү хэв журмын нөхцөл байдалд ажиллах хүч хэрэгслийн бодит боломжийг үнэлэн шинжлэх асуудал мөн чухал байна.

Болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэмт хэрэгт нөлөөлөх хүчин зүйл, шалтгаан, нөхцлийг судалж, эрсдлийг бууруулах дүн шинжилгээ хийх, мөрдөх ажиллагааг амжилттай явуулахад хэрэгцээтэй арга замыг тодорхойлох ажлыг Цагдаагийн төв байгууллага зохион байгуулна.

Ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд холбогдож хохирсон гэмт хэрэгт илүүтэй анхаарал тавьж ажиллахыг нийгмийн зүгээс шаардаж байна. Энэ шаардлагыг хангах үндсэн арга хэрэгсэл нь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага өдөр тутам барьж ажиллах стандарт, зөвлөмжийг боловсруулж нэвтрүүлэх чиглэлд хэрэгжиж байна.

Жишээ нь, хэргийн газрын үзлэг явуулахад ашигладаг азийн болон олон улсын стандартыг гарын авлага болгох, мөрдөх ажиллагааны орчин

үеийн тактикийг боловсруулах, бүртгэгдэж байгаа нийт гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, гомдол мэдээллийн урсгал болон ажлын ачааллыг хянаж шинжлэх, байгууллагын үйл ажиллагааны талаарх маркетингийг хөгжүүлж цагдаагийн байгууллагад хандах тохиолдол, хууль зүйн үндэслэлийг сурталчлан, эрхээ хамгаалуулахаар төрийн байгууллагад хандаж байгаа иргэдийг чиглүүлэн туслах нь ч чухал байна.

Түүнчлэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж гэмт хэрэг, зөрчлийн талаарх болон нийгэм, иргэдийн санаа бодол, уур амьсгалыг тодорхойлох ажлыг эрчимжүүлэн явуулах, үүний тулд олон нийттэй төрөл бүрийн хэлбэрээр хамтын ажиллагаа явуулж, нийгмийн сөрөг үзэгдлийн нөлөөллийг бууруулах, мэдээлэлд суурилсан цагдаагийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хэрэгцээ шаардлагыг судлан ажиллаж байна.

Өөрөөр хэлбэл олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа, харилцан дэмжлэг туслалцаа юунаас ч илүү чухал болох нь харагдаж байгаа юм.

Энэ илтгэлд дээр дурьдсанчлан бүтэц, стратеги, хууль эрх зүйн орчин, үйл ажиллагааны технологи, хамтын ажиллагааны шинэчлэлүүд хийгдсэний дараа хууль сахиулах үйл ажиллагаанд хүний оролцоог

аль болох багасган мэдээллийн технологид түшиглэн ажиллах, гэмт хэргийн ул мөрийг илрүүлж, бэхжүүлэх, хадгалах техник, тоног төхөөрөмж, программ хангамж, лабораторийн хөгжүүлэлтийн асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж, практикт нэвтрүүлэх хэрэгтэй болно.

Мэдээж хэрэг бүх тоног төхөөрөмжийг нэг дор худалдаж авах боломжгүй. Ийм учраас нэг тоног төхөөрөмжийг худалдаж авч байхад, нөгөөдөхийг нь худалдаж авах судалгаа төсөл явагдаж байх гэх мэтээр үе шаттай, үндэслэл, тооцоо судалгаатай шинэчлэлт хийгдэнэ.

Жишээ нь, криминалистик шинжилгээний лабораториудыг хими, физик, адилтгалын төрлөөр байгуулж, магадлан итгэмжлэлд оруулах, шинжээч, мэргэжилтнийг бэлтгэх, явуулын лаборатори ажиллуулах, олон нийтэд үйлчлэх сэтгэл зүйн төвүүдийг аймаг, дүүргийн цагдаагийн дэргэд ажиллуулах, эдгээрийн санхүүжилтийг төсвийн додотголд тухай бүр тасралтгүй тусгуулж шийдвэрлүүлэх зэрэг шинээр бий болсон эрх зүйн таатай орчинд түшиглэн зохион байгуулах ажлууд биднийг хүлээж байна.

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХАМГААЛАХ ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ

SAFETY OF POLICE OFFICERS AND USING THE POLICE EQUIPMENTS



Н.Ганбадрал. ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн захирал, хууль зүйн доктор, цагдаагийн дэд хурандаа
Ganbadral.N. Director of institute Police, Law Enforcement University, Ph.D, Police lieutenant colonel

Abstract: Under framework of the legal innovation, the improvement of legal environment of the Law enforcers has been developed. The legislations constituted the issues concerning to risk management of Law Enforcers. However, it still needs some further improvement. Any equipment and tools that are used to meet safety and security requirement of Law enforcer service shall reach internationally allowed standards moreover it would be right step to use those equipment and tools after we collaborate with professional laboratories and scientific institutes that are most suitable for our country's feature and specialties on investigation and research. Everything should be based on those research work.